



"ЖУУЛЧИН ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ

2026 оны 03 сарын 20

№ 02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн 2026 оны 03 дугаар сарын 20 -ны өдрийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Жуулчин говь ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 13.00 цагт “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
 - Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
 - Компанийн ТУЗ-ийн тайлан
 - Аудитын хорооны тайлан
 - ТУЗ-ийн гишүүдийг сонгох
3. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.
 - Комиссын дарга: Д.Сүрэнхорлоо
 - Комиссын гишүүд: Г.Хүрэлбаатар, Ц Мөнхнасан
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Г.Мөнхбилэгийг томилсугай.
5. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.
 - Комиссын дарга: Д.Сүрэнхорлоо
 - Комиссын гишүүд: Г.Хүрэлбаатар, Ц Мөнхнасан
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар мэдээг хүргэх, хуралтай холбогдох асуудлыг зохих хууль, журмын дагуу эрхлэн явуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Ээлжит хурлын зарыг олон нийтэд хүргэх өдрийг 2026 оны 03 дугаар сарын 24-ны өдрөөр, бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дугаар сарын 10 ны өдрөөр тус тус тогтоосугай.
8. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
10. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 13.00 цагаар тасалбар болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА



Г.МӨНХБИЛЭГ

**“Жуулчин говь” ХК-ийн хувцаа эзэмшигчдийн
ээлжит хурлыг зарлан хуралдуулах
тухай тогтоолын хавсралт 1**

**“Жуулчин говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд
оролцох хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичиг**

“Жуулчин говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь дараах бичиг баримттай танилцах эрхтэй болно. Үүнд:

1. “Жуулчин говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлт
4. Аудитын хорооны тайлан
5. Компанийн ТУЗ-ийн тайлан
6. Саналын хуудас
7. Тогтоолын төсөл

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид Улаанбаатар хот, ХУД, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө 36, “Монгол савхи” ХК-ийн байранд хүрэлцэн ирж танилцаж болно.

Хурал зохион байгуулах комисс
Ажиллах цаг: Да-Ба 09.00-17.00
Утас: 345757, 9906016